

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Өргөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайшванд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/224

танай _____-ны № _____-т

**ӨРГӨН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ТӨГСЖАРГАЛ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Өргөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Өргөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион

010007054

байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд өмнөх оны авлагыг бууруулаагүй, нэмж авлага үүсгэн нийт авлагын хэмжээ өмнөх онтой харьцуулбал 40%-аар, мөн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг 57%-аар өсгөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай тайлант онд гарсан бүх тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн ба 5 тушаал огт мэдээлээгүй байна.

Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 17 ширхэг 72,6 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 2 ширхэг 0.71 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Техно зон ХХК, Тас сайн ХХК-аас шууд худалдан авалтаар таблет болон өнгөт принтер шууд худалдан авалтаар авсан бөгөөд цахим дэлгүүрт хандаагүй худалдан авах жагсаалт илгээгээгүй. Эдгээр зөрчлүүд нь үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	169,393,056.69	138,303,653.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	114,771,826.28	85,802,522.29
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	114,771,826.28	85,802,522.29
31210	Төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах	106,496,492.28	85,802,522.29
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	8,275,334.00	0.00
33	АВЛАГА	1,518,439.00	2,134,439.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	745,589.00	745,589.00
33500	Бусад авлага	772,850.00	1,388,850.00
33510	Байгууллагаас авах авлага	772,850.00	1,388,850.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,102,794.41	50,366,691.97
35100	Түүхий эд материал	16,171,511.45	17,128,759.45
35110	Тусгай зориулалттай материал	16,171,511.45	17,128,759.45
35400	Хангамжийн материал	34,351,279.96	30,657,932.52
35410	Бичиг хэргийн материал	6,405,000.00	332,000.00
35420	Аж ахуйн материал	21,479,443.00	23,317,058.00
35460	Хүнсний материал	241,905.00	360,850.00
35470	Бусад хангамжийн материал	6,224,931.96	6,648,024.52
35600	Мал амьтад	2,580,000.00	2,580,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,586,502,481.82	1,667,619,815.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,586,502,481.82	1,667,619,815.99
39200	Биет хөрөнгө	1,558,026,794.10	1,640,703,378.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,668,548,572.00	1,782,647,156.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-182,825,286.77	-232,199,544.41
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	157,988,262.31	179,163,837.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-110,961,856.18	-111,626,704.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,851,917.58	75,480,798.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,591,551.41	-64,683,463.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,426,460.00	4,426,460.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,405,900.00	-4,405,900.00
39217	Ном	10,996,176.57	11,900,739.07
39300	Биет бус хөрөнгө	28,475,687.72	26,916,437.84
39301	Програм хангамж	6,597,000.00	6,597,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,547,312.28	-3,106,562.16
39303	Бусад биет бус хөрөнгө	23,426,000.00	23,426,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,755,895,538.51	1,805,923,469.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,085,855.29	3,275,736.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,085,855.29	3,275,736.29
41300	Өглөг	2,085,855.29	3,275,736.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,974,255.29	503,126.29
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	779,300.00
41360	Бусад өглөг	111,600.00	1,993,310.00
41361	Байгууллагад төлөх өглөг	500.00	1,882,210.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	111,100.00	111,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,753,809,683.22	1,802,647,732.96
51	Засгийн газрын хувь оролцоо	1,753,809,683.22	1,802,647,732.96
51100	Засгийн газрын оруулсан капитал	667,016,792.49	667,016,792.49
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	667,016,792.49	667,016,792.49
51200	Хуримтлагдсан үр дүн	286,518,247.26	335,356,297.00
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,449,687,152.96	286,518,247.26
51220	Тайлант үеийн үр дүн	1,736,205,400.22	48,838,049.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	800,274,643.47	800,274,643.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,755,895,538.51	1,805,923,469.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,453,162,304.99	896,633,205.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,701,588,263.58	132,951,350.06
120	Нийтлэг татварын бус орлого	1,701,588,263.58	132,951,350.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	625,150.00	1,750,948.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	625,150.00	1,750,948.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,648,338,276.60	128,643,146.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	52,624,836.98	2,557,255.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,574,041.41	763,681,854.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	604,410,000.00	628,871,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	604,410,000.00	628,871,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,164,041.41	134,810,054.94
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,164,041.41	134,810,054.94
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	707,260,567.97	847,795,155.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	707,260,567.97	847,795,155.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,536,067.97	805,167,577.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,817,524.24	490,732,443.86
210101	Үндсэн цалин	284,780,856.30	346,108,040.93
210102	Нэмэгдэл	92,417,254.81	125,571,255.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	15,619,413.13	14,377,313.97
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	4,675,833.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,934,463.42	60,805,211.43
210201	Тэтгэврийн даатгал	30,038,055.78	42,078,747.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,113,986.04	4,950,440.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,266,748.81	3,925,152.80
210204	Ажилгүйдлийн даатгал	774,149.90	895,534.23
210205	Эрүүл мэндийн даатгал	7,741,522.89	8,955,335.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,645,726.76	131,664,384.94
210301	Гэрэл, цахилгаан	3,114,129.76	5,027,263.94
210302	Түлш, халаалт	118,077,367.70	118,296,013.00
210303	Цэвэр, бохир ус	5,454,229.30	8,341,108.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,393,250.00	1,081,510.00
210401	Бичиг хэрэг	2,213,200.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,162,300.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,017,750.00	0.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	1,081,510.00
2105	Нормативт зардал	11,952,295.00	13,207,625.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	114,150.00
210502	Хоол, хүнс	11,952,295.00	13,093,475.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	387,000.00	207,000.00
210604	Урсгал засвар	387,000.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	6,549,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,757,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	4,792,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,865,808.55	100,919,502.33

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,217,190.57	26,764,390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,160.00	4,559,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,600,457.98	69,595,812.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,724,500.00	42,627,577.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,724,500.00	42,627,577.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,794,500.00	28,351,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,930,000.00	14,276,077.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,745,901,737.02	48,838,049.74
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,896,336.80	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	9,896,336.80	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,736,295,400.22	48,838,049.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	761,291,992.41	773,000,802.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,717,951.00	9,318,948.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,717,951.00	9,318,948.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,717,951.00	1,750,948.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,129,117.00	202,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,548,548.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	7,588,834.00	0.00
120009	Бусад орлого	0.00	7,568,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,574,041.41	763,681,854.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	604,410,000.00	628,871,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	604,410,000.00	5,026,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,164,041.41	134,810,054.94
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,164,041.41	134,810,054.94
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	630,059,166.13	779,900,106.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,059,166.13	779,900,106.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593,334,666.13	735,121,529.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,127,827.76	499,771,842.86
210101	Үндсэн цалин	266,959,611.82	355,147,439.93
210102	Нэмэгдэл	91,749,156.81	125,571,255.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	17,419,059.13	14,377,313.97
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	4,675,833.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,172,561.61	60,804,941.43
210201	Тэтгэврийн даатгал	37,276,153.97	42,078,747.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,113,986.04	4,950,170.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,266,748.81	3,925,152.80
210204	Ажилгүйдлийн даатгал	774,149.90	895,534.23
210205	Эрүүл мэндийн даатгал	7,741,522.89	8,955,335.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,859,526.76	131,810,884.94
210301	Гэрэл, цахилгаан	3,114,129.76	5,027,263.94
210302	Түлш, халаалт	118,077,367.70	118,296,013.00
210303	Цэвэр, бохир ус	5,668,029.30	8,487,608.00
2105	Нормативт зардал	12,017,100.00	10,985,120.00
210502	Хоол, хүнс	12,017,100.00	10,985,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,355,680.00	2,999,170.00
210604	Урсгал засвар	4,355,680.00	2,999,170.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	4,994,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	202,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	4,792,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,261,970.00	23,755,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,686,910.00	16,565,870.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,575,060.00	7,189,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,724,500.00	44,778,577.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,724,500.00	44,778,577.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,794,500.00	30,502,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,930,000.00	14,276,077.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	131,232,826.28	-630,744,203.99
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,461,000.00	22,070,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,461,000.00	22,070,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,461,000.00	22,070,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,461,000.00	22,070,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-16,461,000.00	-22,070,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	114,771,826.28	-652,814,203.99
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	114,771,826.28
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	114,771,826.28	85,802,522.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	667,016,792.49	814,280,463.47	- 1,449,687,152.96	31,610,103.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	667,016,792.49	814,280,463.47	- 1,449,687,152.96	31,610,103.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-14,005,820.00	0.00	-14,005,820.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,736,205,400.22	1,736,205,400.22
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,016,792.49	800,274,643.47	286,518,247.26	1,753,809,683.22
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	667,016,792.49	800,274,643.47	286,518,247.26	1,753,809,683.22
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	667,016,792.49	800,274,643.47	286,518,247.26	1,753,809,683.22
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	48,838,049.74	48,838,049.74
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	667,016,792.49	800,274,643.47	335,356,297.00	1,802,647,732.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	741,256,300.00	662,230,051.99	79,026,248.01	89%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	741,256,300.00	662,230,051.99	79,026,248.01	89%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	691,977,700.00	622,381,474.29	69,596,225.71	90%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,071,300.00	499,771,842.86	52,299,457.14	91%
210101	Үндсэн цалин	378,440,200.00	355,147,439.93	23,292,760.07	94%
210102	Нэмэгдэл	151,156,600.00	125,571,255.88	25,585,344.12	83%
210104	Урамшуулал	22,474,500.00	14,377,313.97	8,097,186.03	64%
210105	Гэрээт ажлын хөлс	0	4,675,833.08	-4,675,833.08	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,009,100.00	60,804,941.43	8,204,158.57	88%
210201	Тэтгэврийн даатгал	46,926,300.00	42,078,747.69	4,847,552.31	90%
210202	Тэтгэмжийн даатгал	5,520,700.00	4,950,170.96	570,529.04	90%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,416,500.00	3,925,152.80	491,347.20	89%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,104,200.00	895,534.23	208,665.77	81%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,041,400.00	8,955,335.75	2,086,064.25	81%
2105	Нормативт зардал	10,995,100.00	10,985,120.00	9,980.00	100%
210502	Хоол, хүнс	10,995,100.00	10,985,120.00	9,980.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,230,700.00	4,994,400.00	4,236,300.00	54%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,437,800.00	202,400.00	4,235,400.00	5%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,792,900.00	4,792,000.00	900.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,671,500.00	45,825,170.00	4,846,330.00	90%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,482,200.00	38,635,870.00	4,846,330.00	89%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,189,300.00	7,189,300.00	0.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,278,600.00	39,848,577.70	9,430,022.30	81%
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,278,600.00	39,848,577.70	9,430,022.30	81%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,932,500.00	30,502,500.00	9,430,000.00	76%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,346,100.00	9,346,077.70	22.30	100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	741,256,300.00	630,622,748.00	110,633,552.00	85%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	628,871,800.00	628,871,800.00	0.00	100%
310001	Улсын төсвөөс санхүүжих	628,871,800.00	628,871,800.00	0.00	100%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	112,384,500.00	1,750,948.00	110,633,552.00	2%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,437,800.00	202,400.00	4,235,400.00	5%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,450,200.00	1,548,548.00	-98,348.00	107%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	106,496,500.00	0		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	106,496,492.28		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	74,889,188.29		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 112,995.65 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлангийн уялдаа холбоог шалгахад 22,517.29 мянган төгрөгийн зөрүү гарч залруулга хийв.
- Санхүүгийн байдлын тайлангаар мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн баталгаанаас зөрүүтэй байсан 85,802.52 мянган төгрөгийг залруулав.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд олгосон цалин хөлсийг гэрээт ажлын хөлс гэдэг дансанд гаргаж эдийн засгийн ангилал зөрүүлж бүртгэсэн, батлагдсан төсвийн мэдээлэл дутуу оруулсан 4,675.83 мянган төгрөгийн алдааг залруулав

Аудитаар нийт 3 зөрчил илэрснээс цаашид давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өгч ажилласан.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 17 ширхэг 72,6 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 2 ширхэг 0.71 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд цахим төлбөрийн нэхэмжлэх үүсгүүлж, төлбөр төлөх үед төлбөрийн баримт үүссэн эсэхийг тогтмол хянаж байх, цахим төлбөрийн баримт олгох газруудаас худалдан авалт хийх.

Илрүүлэлт 2: Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд өмнөх оны авлагыг бууруулаагүй, нэмж авлага үүсгэн нийт авлагын хэмжээ өмнөх онтой харьцуулбал 40%-иар өсгөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх оны авлагыг бууруулах арга хэмжээ авч, нэмж авлага үүсгэхгүй байх талаар анхааран ажиллахыг зөвлөлөө.

Илрүүлэлт 3: Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөрийг 57%-иар өсгөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх оны өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, нэмж өр төлбөр үүсгэхгүй байх талаар анхааран ажиллахыг зөвлөлөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		/мянган төгрөгөөр/
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		
							Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн уялдаа холбоог шалгахад зөрүү гарч залруулга хийв.	1	22,517.30			1	22,517.30	1	22,517.30	
Санхүүгийн байдлын тайлангаар мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн баталгаанаас зөрүүтэй байсныг залруулав.	1	85,802.52			1	85,802.52	1	85,802.52	
Төсвийн гүйцэтгэлийн тайланд олгосон цалин хөлсийг гэрээт ажлын хөлс гэдэг дансанд гаргаж эдийн засгийн ангилал зөрүүлж бүртгэсэн, батлагдсан төсвийн мэдээлэл дутуу оруулсныг залруулав.	1	4,675.83			1	4,675.83	1	4,675.83	
ДҮН	3	112,996			1	112,995.65	1	112,995.65	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		/мянган төгрөгөөр/
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд өмнөх оны авлагыг бууруулаагүй, нэмж авлага үүсгэн нийт авлагын хэмжээ өмнөх онтой харьцуулбал 40%-иар өсгөсөн байна.	1	2,134.44					1	2,134.44			
Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат ер төлбөрийг 57%-иар өсгөсөн байна.	1	3,275.74					1	3,275.74			
ДҮН	2	5,410.2	-	-	-	-	2	5,410.2	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай тайлант онд гарсан бүх тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн ба 5 тушаал огт мэдээлээгүй байна.	1	384.36			1		384.36
ДҮН	1	384.36			1		384.36
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Техно зон ХХК, Тас сайн ХХК-аас шууд худалдан авалтаар таблет болон өнгөт принтер шууд худалдан авалтаар авсан бөгөөд цахим дэлгүүрт хандаагүй худалдан авах жагсаалт илгээгээгүй.	1	22,070.00			1		22,070.00
Еbагimт- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 17 ширхэг 72,6 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 2 ширхэг 0.71 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.	1	711.00			1		711.00
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна.	1	35,970.00			1		35,970.00
ДҮН	3	58,751.00			3		58,751.00